



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 5/31

Чингис хот

Ажлаас чөлөөлж, түр орлон гүйцэтгэгч  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 22 дугаар зүйлийн 22.1, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.2, 3.2.7, 4.2, 4.2.3, 4.4, 5.1, 2014 оны "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өөр ажилд шилжин ажиллах болсон Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхбаатарыг 2017 оны 06 дугаар сарын 09-ний, Санхүү, төрийн сангийн хэлтсийн төрийн сангийн мэргэжилтэн Б.Амгаланбаатарыг 2017 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Санхүү, төрийн сангийн хэлтэст төрийн сангийн мэргэжилтэн томилогдох хүртэлх хугацаанд төрийн сангийн мэргэжилтэн Б.Онончимэгийг албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

3. Д.Мөнхбаатар, Б.Амгаланбаатар нартай холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д даалгасугай.

4. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ж.Гантулга -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Ч.Болормаа -Архив, бичиг хэргийн эрхлэгч

Л.Очирмаа -Аж ахуйн нярав

ДАРГА



Ж.ГАНБААТАР